

ОРОН НУТГИЙН СОНИН

НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ХЭЛТЭС | 2015 ОНЫ АРВАННЭГДҮГЭЭР САР



ОЮУ ТОЛГОЙН ДАЛД УУРХАЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ФОРУМ БОЛЛОО

(2-р нүүрт)



БАЯН
БАГИЙНХАН
1000 БОТГОНЫ
БАЯРАА ИНГЭЖ
ТЭМДЭГЛЭВ

(3-р нүүрт)



“ИХ ГОВИЙН АЯЛГУУ”-Г
ЧАГНААРАЙ

Үлэг гүрвэлийн мөрийг өдий
хүртэл хадгалсан өмнийн
цэнхэр говь үлгэрийн
гайхамшигт диваажин билээ.

(5-р нүүрт)



Ж.БАТТУЛГА: “ОЮУ
ТОЛГОЙ”-ТОЙ
ХАМТАРЧ АЖИЛЛАНА
ГЭДЭГ НЭР ТӨРИЙН
ХЭРЭГ ШҮҮ ДЭЭ

(10-р нүүрт)

ОЮУ ТОЛГОЙН ДАЛД УУРХАЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ФОРУМ БОЛЛОО



Дотоодын болон гадаадын ханган нийлүүлэгчдийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжих зорилготой Оюу толгойн Далд уурхайн бүтээн байгуулалтын Ханган нийлүүлэгчдийн форум 11 дүгээр сарын 4-нд боллоо. Энэхүү арга хэмжээ нь боломжит ханган нийлүүлэгчдийг олох, тэдэнд далд уурхайн бүтээн байгуулалтын төслийн талаар мэдээллийг өгөхөд чиглэгдсэн бөгөөд Монголын болон олон улсын 600 орчим компани идэвхтэй оролцож, арга хэмжээнд 1200 гаруй хүн ирсэн юм.

“Оюу толгой” ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал Эндрью Вүдлэй “Далд уурхайн бүтээн байгуулалтын энэхүү форум нь Оюу толгойн далд уурхайг хөгжүүлэхэд томоохон ахиц дэвшил авчрах чухал үйл явдал болж байна. Оюу толгойн нийт үнэ цэнийн 80 гаруй хувийг агуулсан далд уурхайн төслийг хэрэгжүүлэхэд тогтвортой хамтын ажиллагаа, түншлэл, хамтын хичээл

зүтгэл шаардлагатай. Форумд 600 орчим компани идэвхтэй оролцож, дотоодын болон гадаадын ханган нийлүүлэгч нарт хамтран ажиллах томоохон боломжийг олгож, дэлхийд өрсөлдөхүйц дотоодын үр чадварыг бий болгоход дэмжлэг үзүүлж байгаад бид бүхэн баяртай байна” гэж хэлсэн үгэндээ онцоллоо.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан “Оюу толгой нь аюулгүй, тогтвортой, үр ашигтай, дэлхийд тэргүүлэгч бизнесийг бүтээж байна. “Оюу толгой” компани нь нийгэм, боловсролын салбарт хөрөнгө оруулж, аюулгүй байдал, байгаль орчны гүйцэтгэл, татвар төлөлтөд дэлхийн стандартыг тогтоосон. “Оюу толгой” компанийн үр ашгийг нэмэгдүүлэхэд ханган нийлүүлэгч та бүхний оролцоо маш чухал. Тиймээс ханган нийлүүлэгчид дор бүрнээ үр ашгийг дээшлүүлж, Оюу толгойд хувь нэмрээ оруулж,

дэмжиж хамтран ажиллахыг урьж байна” хэмээн хэллээ.

Энэ үеэр төсөлд шаардлагатай үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламж, их хэмжээгээр хэрэглэх материалууд, өрөмдлөг, өрөмдлөгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, цахилгааны болон харилцаа холбооны хэрэгсэл, галын аюулаас сэргийлэх үйлчилгээ, тоног төхөөрөмж, хөдөлгөөнт тоног төхөөрөмж, дагалдах үйлчилгээ, тээвэр зууч, ложистик, түлшний систем, далд уурхайн тулгуур бэхэлгээний материал, хоолой, шахуурга, боловсруулалт болон материалын дэд бүтэц, мэргэжлийн үйлчилгээ, далд уурхайн хоргодох байр, металл хийц, төмөр, агааржуулалтын тоног төхөөрөмж, дагалдах үйлчилгээ, уурхайн үйлчилгээ гэсэн хангамж, үйлчилгээний 16 багц ангиллаа танилцууллаа.

Түүнчлэн үндэсний болон 28 өөр орноос ирсэн ханган нийлүүлэлт хариуцсан мэргэжилтнүүд аюулгүй ажиллагаа, бизнесийн ёс зүй, үр өгөөжтэй түншлэл зэрэг “Оюу толгой” компанитай хамтран ажиллах үндсэн бодлого журамтай танилцахын зэрэгцээ өөрсдийн хэрэгцээт мэдээллийг авсан юм.

Арга хэмжээнд Монголын болон олон улсын 600 орчим бизнесийн төлөөллөөс гадна Рио Тинто болон Оюу толгойн удирдлагууд, “Эрдэнэс Монгол” компанийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, “Эрдэнэс Оюу толгой” компанийн гүйцэтгэх захирал Д.Ганболд нар оролцлоо.

Үүнээс гадна Засгийн газар, орон нутгийн байгууллагын төлөөлөл, Уул уурхай, Зам тээвэр, Аж үйлдвэр, Гадаад хэргийн яамууд, Ерөнхий сайдын ажлын алба, Инвест Монгол болон Ханбогд сумын төлөөлөл ирсэн байна.

БАЯН БАГИЙНХАН 1000 БОТГОНЫ БАЯРАА ИНГЭЖ ТЭМДЭГЛЭВ



Өмнөговь аймгийн Ханбогд сумын Баян багийнхан 1000 ботгоны баяраа энэ сарын 15-нд ёслол тэмдэглэв. Тэднийхэн 2008 оноос хойш 1000 ботго бойжуулсан амжилтаа тав дахь удаагаа ёслол төгөлдөр тэмдэглэж буй нь энэ юм. “Оюу толгой” компани говь нутгийн нүүдэлч малчдын уламжлалт соёлыг хамгаалж, хойч үед өвлүүлэн үлдээх, тэмээний арчилгаа маллагаа, уналга эдэлгээтэй холбоотой зан үйлийг дэлгэрүүлэн сурталчлах үүднээс энэхүү баярын үйл ажиллагаанд байнга оролцон дэмжлэг үзүүлсээр ирсэн билээ. Энэ жилийн 1000 ботгоны баярт Өмнөговь аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч Б.Эрдэнэ-Очир, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Б.Дэндэвсамба, Ханбогд сумын ИТХ-ын дарга Х.Нэхийт, Засаг дарга Х.Буян-

Өлзий, Ахмадын хорооны дарга Х.Амбаа, “Оюу толгой” компанийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал Эндрью Вүдлэй, Нийгмийн харилцааны хэлтсийн захирал Ш.Байгалмаа тэргүүтэй зочид оролцож, тэмээн сүргээ байнга өсгөж, уналга ачлаганд сургаж байгаа Д.Чулуунбат, Ц.Буян-Өлзий, Ч.Мөнхбаяр нарт тусгайлан баяр хүргэж, “Шилдэг залуу тэмээчин” батламж гардуулсан юм. “Оюу толгой” компани 1000 ботгоны баярын үеэр шалгаруулсан сайхан буур, сайхан ингэний түрүү байруудын бай шагнал хоёр сая төгрөгийг ивээн тэтгэв. Энэ баярт Ханбогд сумын бүх багаас гадна зэргэлдээх Баян-Овоо, Цогт-Овоо сум, Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын малчид оролцож, говь нутгийн эрдэнэ болсон тэмээгээ уралдуулан өрсөлдлөө. Энэхүү баярын сайхан ат, сайхан ингэ, сайхан буур, сүүтэй ингэ, өсвөрийн тайлагны уралдааны түрүү байрыг Ханбогд сумын Баян багийнхан хүртсэн бол хурдан тэмээ, өсвөрийн тайлаг, торомны уралдааны түрүүг Баян-Овоо сумынхан авч, Ханбогд сумын Номгон баг, Дундговь аймгийн Дэлгэрхангай сумынхан удааллаа. Баярын үеэр болсон үндэсний бөхийн барилдаанд Өмнөговь аймгийн начин Х.Хишигчулуун түрүүлж, сумын начин Т.Дашжамц үзүүрлэжээ.

“МЭРГЭЖИЛ БҮХЭН САЙХАН” УУЛЗАЛТ



Ахлах ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгоход нь туслах зорилготой “Мэргэжил бүхэн сайхан” уулзалт 10 дугаар сарын 29-нд Ханбогд сумын Соёлын төвд боллоо. Уулзалтыг “Оюу толгой” компани болон Ханбогд сум дахь “Залуучуудын хөгжлийн төв” хамтран зохион байгуулав. Энэ удаагийн зочин илтгэгчээр “Оюу толгой” компанийн Хүний нөөцийн хэлтсийн захирал Л.Мөнх-Оргил оролцож, мэргэжлээ хэрхэн сонгох, хүний нөөц, хувь хүний амжилтын талаар дотно яриа өрнүүллээ. Уламжлалт уулзалтыг цаашид Ханбогд сум дахь “Залуучуудын хөгжлийн төв” зохион байгуулахаар болжээ.



ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨМНӨГОВЬ АЙМАГТ БОЛОВ



Монгол Улсын нийгэм, эдийн засагт чухал ач холбогдол бүхий Оюу толгой, Таван толгой, Нарийн сухайт, Олон овоот зэрэг алт, зэс, нүүрсний орд Өмнөговь аймагт оршдог билээ. Байгалаас заяасан энэ их баялгийг сайн засаглал, сайн менежментээр ашиглаж, олборлолт, орлого, ашиг нь ард түмэндээ ил тод байснаар баялгийн хараалаас тойрч гардаг гэсэн сургаж байдаг. Энэ ч утгаар манай улс ОУИТБС-д нэгдээд арав гаруй жилийн нүүр үзэж байна.

Өмнөговь аймаг ОУИТБС-ын зөвлөлөө шинэчлэн байгуулж үйл ажиллагаагаа эрчимжүүлж байна. Үүний эхлэл нь тус аймагт олборлолт явуулж байгаа 14 компанийн төлөөллийг урьж 11-р сарын 22-нд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан

явдал байлаа. Хэдийгээр говь нутагт их хэмжээний цас орж байгалийн бэрхшээлтэй байсан ч “Оюу толгой”, “Таван толгой”, “Энержи ресурс”, “Эрдэнэс Таван толгой”, “Өсөх зоос” зэрэг 10 гаруй компани, Баян-Овоо, Ноён зэрэг таван сумын удирдлага хэлэлцүүлэгт хүрэлцэн ирж, олборлох үйлдвэрлэлд мөрдөж буй аюулгүй ажиллагааны туршлага, ашиглаж буй хамгийн сүүлийн үеийн багаж тоног төхөөрөмж, нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн ажил, техник технологи, ажиллах хүчин, инженер техникийн шийдлүүд, усан хангамж, улсын болон орон нутгийн төсөвт сүүлийн хоёр жилд төлсөн татвар хураамж, орон нутагт үзүүлсэн биет болон мөнгөн тусламж зэрэг өргөн агуулга бүхий танилцуулга хийлээ. Сумдын удирдлага нутагтаа байрлаж байгаа уул уурхайн компаниудын үйл ажиллагаа сумын ард иргэдэд хэрхэн нөлөөлж байгаа, сумын тохижилт соёжилт, хүн ардын хөдөлмөр эрхлэлт зэрэгт ямар эерэг нөлөө үзүүлж байгаа, сумын төсөвт хэрхэн хөрөнгө төвлөрүүлж байгаа талаар мэдээлэл хийсэн бол аймгийн Татварын газар, Санхүү, төрийн сангийн хэлтсээс уул уурхайн олборлох үйлдвэрлэлээс аймгийн төсөвт хэдий хэмжээний ямар татвар хураамж төвлөрдөг, түүнийг юунд зарцуулж, аймаг орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгаа талаар тодорхой тоо баримтад үндэслэн танилцуулсан юм.

Дээрх танилцуулгыг сонссоны дараа хэлэлцүүлэгт оролцсон иргэд, иргэний нийгмийн төлөөллийнхөн компанийн удирдлага болон илтгэгчдээс сонирхсон зүйлээ асууж санал бодлоо илэрхийллээ. Тэд гадаад зах зээлд нүүрсний үнэ унасантай холбоотой үйл ажиллагаа нь суларсан компаниуд хэдийд хэрхэн сэргэх, Оюу толгойн далд уурхай хэзээ ашиглалтад орох, Хамтын гэрээний биелэлт аль хэр байгаа, нүүрс тээвэрлэх замын тухай гэх мэт тулгамдсан асуудлуудыг сонирхож байв. Өмнөговь аймгийн Засаг даргын орлогч, ОУИТБС-ын аймгийн дэд зөвлөлийн тэргүүн Д.Нацагдорж хэлэлцүүлэг уул уурхайн компаниуд болон орон нутгийнхан мэдээллээ солилцож, харилцан ойлголцсон эерэг таатай уур амьсгалд болсныг онцлон тэмдэглээд хамтын ажиллагаагаа цаашид улам гүнзгийрүүлэн ил тод байдлыг ханган ажиллахыг уриаллаа.

Энэхүү хэлэлцүүлгийг зохион байгуулахад ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн ажлын алба, аймаг, сум дахь дэд зөвлөл, Уул уурхайн үндэсний ассоциац, Нээлттэй нийгэм форум зэрэг байгууллагууд зохион байгуулалтын болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэнд талархлаа илэрхийлэе.

ОУИТБС-ын аймгийн зөвлөлийн гишүүн Б.Зандраа



“ИХ ГОВИЙН АЯЛГУУ”-Г ЧАГНААРАЙ

хөрөнгө оруулагчидтайгаа хамтран энэхүү баялаг ордыг түшиглэн уурхай нээж, баяжуулах үйлдвэр барьж, тэнд боловсруулсан зэсийн баяжмалаа дэлхийн зах зээлд борлуулснаар өмнийн говьд их бүтээн байгуулалт өрнөж, говийнхны ахуй амьдрал, өнгө төрх өөдлөн сэргэж байна. Оюу толгойн уурхай Монгол улсын хөгжил дэвшилд хэдэн арван жилийн турш ихээхэн хувь нэмрээ оруулах гэгээн сайхан ирээдүйтэй. “Оюу толгой” компани зөвхөн уул уурхайн бизнес эрхэлж, Монгол улсын хөгжил дэвшилд дорвитой хувь нэмэр оруулахын зэрэгцээ говь нутаг, говийнхны аж төрөх ёс, түүх, соёлын өв, байгаль орчныг хамгаалах, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр ихээхэн санаа тавьж, цөөнгүй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг юм. Тэр их үйл хэргийн нэгээхэн хэсэг нь эрхэм танаа толилуулан буй “Их говийн аялгуу” хэмээх энэхүү цомог юм. “Оюу толгой” компанийн тусгай захиалгаар Монгол улсын Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Н.Жанцанноровын бүтээсэн “Оюу эрдэнийн говь” симфони чуулбар энэ цомогт бий. “Оюу эрдэнийн говь” симфони чуулбар “Их өглөө”, “Хулангийн тоос”, “Зэрэглээ”, “Угалз”, “Сэтгэлийн гүнээс”, “Ханбогдын эгшиглэн”, “Эрин цаг” гэсэн долоон ангиас бүрдсэн юм. Чихнээ яруу

эгшиглэх энэхүү аялгууг сонсоход чухамхүү үлгэрийн говиор хоромхон зуур аялахдаа тэнд өрнөж буй эрин зууны асар том бүтээн байгуулалтын анир чимээг Та мэдрэх буй за.

“Оюу толгой” компанийн ТУЗ-ийн дарга Г.Батсүхийн шүлэг, Соёлын гавьяат зүтгэлтэн Л.Балхжавын аялгуу “Оюу толгой” дууг мөн цомогт багтаажээ. Г.Батсүх дарга UBS ТВ-ийн “Цай юу, кофе юу” нэвтрүүлгийн 2015 оны 11 дүгээр сарын 8-ны дугаарт оролцож, “Оюу толгой” компанийн сүүлийн үеийн мэдээллээс хуваалцахдаа “Их говийн аялгуу” хэмээх шинэхэн цомгоо бас танилцуулсан юм.

Өмнийн говийн эрдэнэсийн өлгий

Өнгө ногоон Оюу толгой

Ард түмний минь эрдэнийн бэлгэдэл

Алт зэсэн Оюу толгой

хэмээн энэ дуунд өгүүлдэг юм.

“Их говийн аялгуу”-г эрхэм таны сонорт өргөн барья. Таалан соёрхон уу.

“Оюу толгой” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Г.Батсүхийн ярилцлага болон “Их говийн аялгуу” симфони чуулбарыг ot.mn цахим хуудаснаас үзэж сонсох боломжтой.

Үлэг гүрвэлийн мөрийг өдий хүртэл хадгалсан өмнийн цэнхэр говь үлгэрийн гайхамшигт диваажин билээ. Тэлмэн зэрэглээ наадаж, тэмээн сүрэг бэлчсэн тэр л шаргал говь байгалийн өвөрмөц тогтоц, ховор амьтан, ургамал, түүх, соёлын гайхамшигт өв, эртний ховор дурсгалуудаараа дэлхий дахинаа алдар суугаа мандуулсаар. Чухам иймийн учир Дорнын их яруу найрагч Бэгзийн Явуухулан

Говь чухамдаа

Газар дэлхийн толин цэнхэр дэлгэц билээ

Говийн зэрэглээ

Галбын уран дархан билээ

хэмээн дуу алдсан биз ээ. Энэ л говьд өвгөд дээдсийн минь үр хойч бидэндээ үлдээсэн Оюу толгой хэмээх алт, зэсийн баялаг орд байдаг. Монгол улсын Засгийн газар олон улсын

SOS-ЫНХОН ОРОН НУТГИЙНХАНД ЭЭЛТЭЙ



Хүмүүнлэгийн үйл ажиллагаагаа, энэрэнгүй үйлсээрээ олноо алдаршсан Олон улсын SOS байгууллага бараг зуугаад оронд салбартай гэдэг. Тус байгууллагын Монгол дахь салбарын нэг нь Оюу толгойн уурхайд байрладаг SOS клиник юм. Эднийх эмнэлгийн тоног төхөөрөмжөөр тусгайлан бүрэн тоногдсон “Камаз” болон “Ланд крүйзэр” машинтай. Хоногийн аль ч үед яаралтай тусламжийн дуудлага ирэхэд тэр даруй ухасхийн хөдлөхөд бэлэн байдалд байдаг. Энд дамнуурга, шингэн, эм хэрэгслээс эхлээд хүчилтөрөгч, зүрхний аппарат хүртэл цөм бүрэн бий. Монголын аль ч эмнэлэгт байдаггүй ховор, дэлхийн стандартад нийцсэн мундаг тоног төхөөрөмж ч цөөнгүй бий гэж Оюу толгой компанийн Хөдөлмөрийн эрүүл мэнд, гэмтлийн менежмент хариуцсан мэргэжилтэн Э.Дөлгөөн бахархангуй өгүүлж байна лээ. SOS эмнэлэг уурхайн ажилчдад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон

яаралтай тусламжийг өдөр бүр хоногийн 24 цагийн турш үзүүлдэг. Замын ослын дуудлагад явах, рентген, ЭХО болон клиник лабораторийн шинжилгээ хийх, эмнэлгийг нүүлгэн шилжүүлэх, яаралтай тохиолдолд өвчтөн тээвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. 48 ажилтан хоёр ээлжээр ажилладаг. Халдвар судлаач, дүрс оношилгоо, сургалтын эмч, эм зүйч зэрэг гадаадын гурав, монгол арваад эмч, 12 сувялагч, эмнэлгийн менежер, зөвлөх эмч, лаборант, хүлээн авахын ажилтантай. Эрүүл мэндийн анхан болон яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дүрс оношилгоо, ЭХО, зүрхний бичлэгийн аппарат зэрэг тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Хүлээн авахаас эхлээд үзлэг, яаралтай тусламж, тусгаарлах, ариутгал, боолтын зэрэг өрөө, лаборатори, эмийн сантай.

Шээс, цус, биохимийн зэрэг нарийвчилсан шинжилгээ хийх, элэгний В,С вирус илрүүлэх, зүрхний бичлэг хийх, нүдэнд орсон гаднын биетийг авах, хугарал гэмтлийг илааршуулах гээд тун олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Н.Хэрлэнчимэг эмч ярьж байв. Оношийг зөв тогтоосноор аливаа өвчнийг эрт илрүүлж, улмаар эмчилж эдгээхэд сайнаар нөлөөлдөг байна. SOS-ынхон орчин үеийн анагаах ухааны ололт амжилт, мэдээллээс хоцроохгүйн тулд эмч ажилтнуудаа байнга сургадаг. Долоо хоногт хоёр удаа сургалт зохион

байгуулдаг. Тэднийхэн жинхэнэ интернационал хамт олон. Тухайлбал, ерөнхий менежер Брайн Ричи Австрали, Мэли эмч буюу Мелинда Крэкнэл Англиас эрс тэс уур амьсгалтай Монголын өмнийн говьд ажиллахаар зориг шулуудан иржээ.

Оюу толгойн уурхайн хөрш Ханбогд сум өнгөрсөн жил тохилог сайхан эмнэлэгтэй болсон билээ. Гэсэн ч SOS эмнэлгийнхэн тус сумын иргэдэд рентген зураг авч өгөх, яаралтай тусламж үзүүлэх, нарийн мэргэжлийн шинжилгээ хийх, эмнэлгийнхэнд нь сургалт зохион байгуулах, сумын эмнэлгийн чадавхыг сайжруулахад туслах, малчид жирийн иргэдэд эрүүл мэндийн сэдвээр хичээл заах зэргээр зүйл бүрээр тус дэм болдогт нь сумынхан ам сайтай байдаг юм билээ. Чухам ийм учраас тэднийхнийг орон нутгийнханд ээлтэй гэж нэрлэхээс яахав. Оюу толгойн уурхайд саяхан зочилж, SOS эмнэлгийн үйл ажиллагаатай танилцсан “Зууны мэдээ” сонины сэтгүүлч Б.Энхтуул SOS эмнэлгийн талаар сэтгэл ихэд ханамжтай байгаагаа илэрхийлэх ялдамд “тус эмнэлгийнхэн зөвхөн “Оюу толгой”-н ажилчдаас гадна орон нутгийн эмнэлэгтэй хамтран ажиллах, зарим төрлийн үйлчилгээ үзүүлэх зорилго тавин ажиллаж байна. Энэ зорилгынхоо хүрээнд Ханбогд сумын сум дундын эмнэлгийн эмч, сувялагч нарт сургалт явуулах, шаардлагатай үед тус сумын иргэдэд ч бас эмнэлгийн анхан шатны яаралтай тусламжийг үзүүлдэг юм байна” гэж үнэлсэн байна лээ.

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Ханбогд сумы хөгжлийн бэрхшээлтэй иргэд, заавал хөгжих өрхүүдтэй хамтран ажиллах 2015 оны төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдрийг угтаж тэдэнд зориулсан сургалт-өдөрлөгийг саяхан зохион байгуулав. Сумын Засаг дарга Т.Буян-Өлзий өдөрлөгийг нээж үг хэлэв. Уг өдөрлөгт хөгжлийн бэрхшээлтэй 35, заавал хөгжих өрхийн 11 хүн оролцлоо. Уг өдөрлөгөөр харилцаа хандлага, Нийгмийн хамгааллын тухай хуулийн болон олон нийтэд зориулсан төсөл хөтөлбөрийн талаар танилцуулж, төсөл хэрхэн бичих чиглэлээр сургалт явуулав. Мөн иргэдийг идэвхжүүлэх хөгжөөнт тоглоом, АХА, караоке тэмцээнийг зохион байгуулсан юм. Өдөрлөгт оролцсон иргэдийн дунд “САЙН ҮЙЛСИЙН АЯН” өрнүүлж, хүн бүр 1000, түүнээс дээш төгрөгийн хандив цуглуулан хөгжлийн бэрхшээлтэй нэг иргэнд хандив болгон гардууллаа. Өдөрлөгийг Өмнөговь аймгийн Нийгмийн халамжийн хэлтэс, Ханбогд сумын Засаг даргын тамгын газар, Насан туршийн боловсролын төв, “Оюу толгой” компанийн Нийгмийн харилцааны хэлтэс, Залуучуудын хөгжлийн төв хамтран зохион байгуулсан юм.

ОРОН НУТГИЙН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХАНБОГД СУМАНД АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ

“Оюу толгой” ХХК-ийн Хангамжийн хэлтэс, Канадын Royal roads их сургууль, Монгол судлалын Америкийн нийгэмлэг хамтран Өмнөговь аймгийн ханган нийлүүлэгчдийн ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийг гурав дахь жилдээ амжилттай хэрэгжүүллээ. “Оюу толгой” ХХК-д хөдөлмөр хамгааллын хувцас оёж нийлүүлдэг Ханбогд сумын оёдлын ханган нийлүүлэгч “Өлзийт мөнх овоо”, “Аргал хэт” ХХК энэ жил хөтөлбөрт хамрагдаж, санхүү, хүний нөөц, агуулахын менежмент, маркетинг, бүтээмж, ажлын байрны эрүүл ахуй зэрэг чиглэлээр компанийн үйл ажиллагаагаа бүрэн оношлууллаа. Канадын бизнесийн зөвлөхүүд компани тус бүр дээр орчуулагчийн хамт 21 хоног ажиллаж компанийнхаа ашгийг нэмэгдүүлэхийн тулд маркетингийн сурталчилгаагаа хэрхэн хийх, бүтээмжийг хэрхэн нэмэгдүүлэх, ажиллах хүчээ тогтвор суурьшилтай ажиллуулах, эргэлтийн хөрөнгө болон бараа материалын бүртгэлээ сайжруулах, санхүүгийн бүртгэл тайлагналыг боловсронгуй болгох, бүтээгдэхүүнийхээ

чанарыг хэрхэн сайжруулах талаар зөвлөгөө өгч хамтран ажиллав.

Хөтөлбөрийн явцад бизнесийн зөвлөхүүд “Оюу толгой” ХХК-д болон ханган нийлүүлэгчдэд зөвлөмж тайлан гаргаж өгөв. Энэхүү зөвлөмж тайлан нь орон нутгийн ханган нийлүүлэгчид уул уурхайн компаниудаас хараат бусаар ажиллаж, зах зээлээ өргөжүүлэх, бизнестээ сүүлийн үеийн бүртгэл хяналтын системийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанараа сайжруулах, ашиг орлогоо нэмэгдүүлэхэд ач холбогдлоо өгөх юм.

Орон нутгийн ханган нийлүүлэгчдийг хөгжүүлэх хөтөлбөрт урьд жилүүдэд “Оюу толгой” ХХК-д ган бөмбөлгийн тээвэр, ажилчдын автобус унааны түрээсийн үйлчилгээ үзүүлэгч болон цай кофе нийлүүлдэг ханган нийлүүлэгчид хамрагдаж, үйл ажиллагаагаандаа ахиц дэвшил гаргаж, ханган нийлүүлэлтийн найдвартай сүлжээг бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулж байгаа билээ.

ХАНБОГД, МАНЛАЙ, БАЯН-ОВОО СУМЫН МАЛЧИД ХАЛИУТ ХОШУУНД ЗОЧИЛЖ ТУРШЛАГА СОЛИЛЦЛОО



*Ханбогд, Манлай,
Баян-Овоо сумын 11
малчин энэ сарын
16-19-нд ӨМӨЗО-ы
Халиут хошуунд
зочлов. Тэд мах
боловсруулах болон
малын тэжээлийн
үйлдвэр, өвлийн
хүлэмж, хөдөө
аж ахуйд тоног
төхөөрөмжийг*

*хэрхэн ашиглаж байгаатай танилцан малчин
айлуудаар орж туршлага солилцлоо. Уг аяллыг
“Монгол говийн нүүдэлч малчдын холбоо” ТББ
“Оюу толгой” компанийн дэмжлэгтэйгээр
зохион байгуулсан юм. “Монгол говийн нүүдэлч
малчдын холбоо”-ны тэргүүн С.Мааманхүүтэй
энэхүү аяллын талаар ярилцлаа.*

Энэ аяллын онцлог нь юу вэ?

Энэхүү аялалд малаа маллаад явж байгаа жирийн малчид оролцсон юм. “Мянга сонсохоор нэг үз” гэдэг шиг өөрсдийн нүдээр үзээд өөр улс орныхон яаж амьдарч байна, би мянгат малчин болоод малын боол болчихож уу, манай мал чанарлаг таваарлаг байж чадаж байна уу,

би хаана нь явж байна гэж өөрийгөө дүгнэж цэгнэсэн аялал боллоо. Махны үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаад аймагтаа ийм нэг үйлдвэр байгуулах бүрэн боломж байна гэж бодож байна. Харин орон нутаг төр захиргааны дэмжлэг үүн дээр зайлшгүй хэрэгтэй.

Өвөр Монголын малчдын давуу тал юу байна вэ?

Бид өглөө босоод л харсан нүд цавчихгүй, хашгирсан дуу тасрахгүй, малаа дагаад явдаг. Энд бол тийм зүйл алга. Учир нь, бэлчээр хашаатай. Засгийн зохицуулалт тусламж их байна.

Өвөр Монголын төр засгаас 10 бүрхүүл хэрэгжүүлдэг юм байна. Үүнд нь ус, цахилгаан, нөхөн олговор, амьдрах байшин гэх мэт ордог гэж ярьж байна. Айл бүр малын тэжээлийн ургамал тариалж байна.

Манай малчдад хоршоогоороо хамтарч бизнес эрхлэх боломж байна уу?

Өөр гарц бол байхгүй. Жалгандаа хэчнээн жил суухав дээ. Үүнийгээ бид халах ёстой. Дээрээс нь захиргаадах биш, өөрсдөө нийлж хамтрах нь чухал. Үүнийг олон улсад нөхөрлөл гэдэг. Хоршоо нөхөрлөлийг хөгжүүлж байгаа хүмүүс

хэдхэн хүн нь зүтгээд бусдыгаа орхидог. Ингэж тус тусдаа зүтгэж болохгүй. Нэгнээ чирээд ч гэсэн хамтдаа явах нь зүйтэй. Бас нэг чухал зүйл нь баг, сум, аймаг малчдад урам хайрлах хэрэгтэй. Малчид төр засгаас юм нэхдэггүй шүү дээ. Орон нутаг тэргүүний нөхөрлөл, тэргүүний бүлэг ч гэдэг юм уу шалгаруулж урам өгмөөр байгаа юм.

Өвөр Монголын малчдаас хамгийн түрүүнд суралцаж нэвтрүүлэх туршлага юу байв?

Тэжээлийн ургамал тариалахыг сурч хэрэгжүүлмээр байлаа. 0.5 сот газраас хоёр тн орчим эрдэнэ шиш хураан авч байгааг нүдээр үзлээ. Малчин хүн мянган ухаантай байдаг учраас нэг л хараад үүнийг хийж чадна гэдэгт би итгэлтэй байна. Бид чанаргүй олон мал маллаж байгаа юм шиг санагддаг. Манай малчид хоорондоо малын чанараар биш тоогоороо битүүхэн өрсөлддөг. Энэ бол маш буруу. Чанартай, өөрсдийн хүчин чадалд тохирсон тооны мал маллах хэрэгтэй. Харин үеийн үед, үрийн үрд захих зүйл гэвэл бэлчээрийг хувьчилж болохгүй юм байна. Тэгвэл нүүдэлчин монгол гэдэг утгаа алдчихна. Нүүдэлчин монгол гэдэг чинь дэлхийд гайхагдсан уламжлал шүү.

Говийн малчин, мал хоёр бол Монголын брэнд юм.

ЧИХРИЙН ШИЖИН

Мэдээллийг бэлтгэсэн СОС эмнэлэг



Чихрийн шижин гэж юу вэ?

Чихрийн шижин нь бие махбодь инсулинийг үйлдвэрлэх, хэрэглэхтэй холбоотой үүсдэг архаг өвчин. Инсулин бол нойр булчирхайнаас ялгарч, цусны чихрийн хэмжээг зохицуулдаг даавар. Бие махбодь хангалттай инсулин үйлдвэрлэж чадахгүй эсвэл инсулинг үр дүнтэй хэрэглэж чадахгүй болмогц чихрийн шижин үүсдэг. Энэ үед цусны чихэр хэвийн хэмжээнээс ихэсдэг.

1-р хэлбэрийн чихрийн шижин

Инсулин хамааралт, хүүхдийн чихрийн шижин гэдэг. Энэ үед бие махбодь хангалттай инсулин үйлдвэрлэж чаддаггүй учраас түүнийг өдөр бүр хэрэглэх шаардлагатай болдог.

1-р хэлбэрийн чихрийн шижингийн шинж тэмдэг:

- Цангах, өлсөх, их шээх, ядрах
- Турах
- Нүд бүрэлзэх

Эдгээр шинж тэмдгүүд гэнэт илэрдэг.

2-р хэлбэрийн чихрийн шижин

Насанд хүрэгчдийн чихрийн шижин гэдэг. Энэ үед бие махбодь инсулинг үр дүнтэй хэрэглэж чаддаггүй. Чихрийн шижинтэй хүмүүсийн 90 хувь нь 2-р хэлбэрийнх байдаг.

Чихрийн шижингийн 2-р хэлбэрээс сэргийлэх боломжтой.

2-р хэлбэрийн чихрийн шижингийн шинж тэмдэг:

Зовиур илрэхгүй байж болно. Эсвэл 1-р хэлбэрийнхтэй адил ам цангах, их шээх зэрэг шинжүүд бүдэг илэрдэг. Ихэвчлэн хүндэрсэн үедээ оношлогддог.

2-р хэлбэрийн чихрийн шижингийн засч болох эрсдэлт хүчин зүйл:

Илүүдэл жин

- Хөдөлгөөний дутагдал
- Дасгал хөдөлгөөн биеийн жингээ барихад болон бие махбодь инсулинг үр дүнтэй хэрэглэхэд тусалдаг.
- Зохисгүй хооллолт
- Зохистой хооллолт биеийн жин, цусны чихрийг зохицуулахад тусалдаг.
- Тамхидалт
- Тамхидалт цусны чихрийн хэмжээг ихэсгэж, бие махбодийн инсулин хэрэглэх чадварыг бууруулдаг.
- Цусны даралт, холестерол ихсэх

Хоёулаа эрсдэлийг нэмэгдүүлдэг. Танд эдгээр асуудал байгаа бол хяна, байхгүй бол эдгээрээс урьдчилан сэргийл.

Чихрийн шижингийн урьдал байдал: Дохио

Чихрийн шижингийн урьдал байдал гэдэг нь цусны чихэр хэвийн хэмжээнээс ихэссэн

ч чихрийн шижин гэж оношлох хэмжээнд хүрээгүй үеийг хэлдэг.

Чихрийн шижингийн урьдал үед шинж тэмдэг илэрдэггүй...

- Жил бүр чихрийн шижингийн урьдалтай хүмүүсийн 30 хүртэлх хувь нь 2-р хэлбэрийн чихрийн шижингээр өвддөг.
- 2-р хэлбэрийн чихрийн шижинтэй хүмүүс чихрийн шижингийн урьдал байдалд байснаа мэдээгүй байдаг.
- “Глюкозод тэсвэрт чанар”, эсвэл “Өлөн үеийн чихэр” –ийг үзэж оношилно.
- Цусны чихрийн хэмжээг бууруулбал 2-р хэлбэрийн чихрийн шижингээс сэргийлж, эсвэл түүгээр өвдөхийг хойшлуулна.
- Чихрийн шижингийн урьдлын үед судасны гэмтэл аль хэдийн үүссэн байж болно.

Чихрийн шижингийн урьдал байдал эмчлэгддэг

Чихрийн шижингийн урьдал байдал эмчлэгддэг, эдгэрдэг! Амьдралын зөв хэв маяг баримтлах нь маш үр дүнтэй. Үүнд зохистой хооллолт, биеийн жингээ бууруулах, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх багтдаг.

Та эрүүл мэнддээ санаа зовж байвал эмчтэйгээ өнөөдөр ярилцаарай. Хэрэв та жирэмсэн, эсвэл 45 аас дээш настай бол чихрийн шижингээр өвдөх илүү эрсдэлтэй тул шинжилгээ өгөөрөй!

Ж.БАТТУЛГА: “ОЮУ ТОЛГОЙ”-ТОЙ ХАМТАРЧ АЖИЛЛАНА ГЭДЭГ НЭР ТӨРИЙН ХЭРЭГ ШҮҮ ДЭЭ



“Оюу толгой” компани гадаад, дотоодын 1200 гаруй ханган нийлүүлэгчтэй. Тэдний нэг нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Галба өртөө” компани юм. Тэднийх Оюу толгойн уурхайн ажилчдад хүнсний бүтээгдэхүүн нийлүүлдэг. Тус компанийн гүйцэтгэх захирал Жамсранжавын Баттулгатай ярилцлаа.

“Галба өртөө” компанийн тухай дурсамжаар ярилцлагаа эхэлье?

Манай компани 2012 онд байгуулагдсан шинэхэн аж ахуйн нэгж. Өмнөговь аймгийн Ханбогд суманд байрлаж, дэн буудал, найман нэрийн барааны дэлгүүр, хүнсний бөөний төв

ажиллуулж, хүнсний худалдаа үйлчилгээ эрхэлдэг юм. Хадаас, эрэг шураг, цоож гэх мэт барилгын багаж хэрэгсэл худалддаг дэлгүүртэй. Менежер, худалдагч, галч, нягтлан бодогч, ачигч гээд найман хүнийг ажлын байраар хангаж байна. Ханбогддоо яг засмал зам дагуу байршилтай учраас борлуулалт, гүйлгээ, орлого ер нь гайгүй шүү.

Та аль нутгийн хүн бэ. Өөрийгөө танилцуулна уу?

Төв аймгийн Алтанбулаг суманд эхээс мэндэлж хүй цөглөж хүн болсон. Аравдугаар ангиа нутагтаа төгсөөд дараа нь армид гурван жил алба хаалаа. Эхлээд Улиастайд, дараа нь Зүүнбаянд олон аавын хөвгүүдтэй залуу насны ид хавыг гайхуулж явлаа. Хожим нь ХНХ буюу холбооны нууцалсан хэрэгслийн мэргэжлээр армидаа найман жил ажилласан. Тэгээд 1996 оноос хувиараа бизнес эрхэлж байна даа. Ханбогдод ирж суурьшаад арав гаруй жил болжээ. Эхнэр Содномдоржийн Насандулам маань орос хэлний багш, “Боловсролын тэргүүний ажилтан” цолтой. Ханбогд сумынхаа ЕБС-д 20 шахам жил багшилж байгаа. Хоёр хүүтэй. Хүү Дашням маань Монголын үндэсний

их сургуульд газар зохион байгуулагчийн мэргэжлээр сурч байгаа, одоо гуравдугаар курс. Ганзориг хүү минь Ханбогддоо аавынхаа бизнест тус дэм болоод манай компанид менежерээр ажиллаж байна.

“Оюу толгой” компанийн ханган нийлүүлэгч болсон тухайгаа яриач?

Ер нь “Оюу толгой” компанитай хамтран ажиллах болсноор ирээдүйдээ үнэхээр сэтгэл хангалуун байх болсон шүү. Товчхон хэлбэл, энэ том компанитай хамтран ажиллана гэдэг үнэхээр нэр төрийн хэрэг. Анх 2013 онд Оюу толгойн уурхайн ажилчдад цай, кофе, хүнсний бүтээгдэхүүний ханган нийлүүлэгчийг шалгаруулах тендер зарласан юм. Уг тендерт ороод шалгарсан. Үнэнийг хэлэхэд шинэ тутам байгуулагдсан орон нутгийн жижиг аж ахуйн нэгжид ялна гэсэн итгэл найдвар бараг байгаагүй гэж хэлж болно. “Оюу толгой” компани тендерээ үнэхээр шударга явуулдаг юм байна лээ. 5-6 компани тэр тендерт оролцоод манайх шалгарсан. Ингээд 2014 оны дөрөвдүгээр сарын 1-нээс Оюу толгойн уурхайн ажилчдад хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулаад энэ хавраас гэрээгээ 2017 оны дөрөвдүгээр сар хүртэл хоёр жилээр сунгаад ажиллаж байна.

Оюу толгойн уурхайн ажилчдад хүнсний бүтээгдэхүүн нийлүүлснээс хойш жил гаруйн хугацаа өнгөрчээ. Энэ хооронд хэдийн хэмжээний бүтээгдэхүүн борлуулав?

Барагцаалбал, 900 гаруй сая төгрөгийн

бүтээгдэхүүн нийлүүлжээ. Бараг тэрбум хүрэх нь байна шүү дээ.

“Оюу толгой” компанитай хамтарч ажилласны үр өгөөж, давуу тал гэвэл та юу хэлэх вэ?

Өө зөндөө байлгүй яах вэ. Хамгийн чухал нь гэхэд л компани ч, ажилчид ч адилхан хариуцлагад, аюулгүй ажиллагаанд суралцаж дасан зохицож байна. Үүний ачаар компанийн маань үйл ажиллагаа илт сайжирч, ашигтай ажиллаж байна. Оюу толгойн уурхайн захиалгаар хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүнийг нь манай ажилчид хэлтсүүдэд хүргэж өгдөг. Уурхайнхнаас манай үйлчилгээний талаар нэг ч удаа гомдол шүүмжлэл гаргаж байгаагүйг бодоход бид тэдний итгэлийг дааж байгаа юм байна даа гэж урамшдаг. Хамгийн гол нь манайх бүтээгдэхүүнийхээ хугацаа, чанарыг эрхэмлэдэг. XXI зууны Монголын хамгийн том бүтээн байгуулалт болох Оюу толгойн уурхайнхны итгэл найдварыг алдахгүй юмсан гэж манайхан чин сэтгэлээсээ хичээн зүтгэдэг юм. Оюу толгойн уурхайн удирдлага ч биднийг зүйл бүрээр дэмждэг. Тухайлбал, Канад, Австралиас мэргэжилтэн урьж ирүүлээд манайханд сарын хугацаатай сургалт зохион байгуулж байна шүү дээ. Манайхан ч заасныг нь сайн сурч ажил хэрэгтээ бүтээлчээр ашиглаж, бүр хэвшил болгосныг хэлэхэд таатай байна.

Бизнесийнхээ, компанийнхаа ирээдүйг хэрхэн төсөөлж байна вэ?

Тун өөдрөгөөр төсөөлж байна. Ханбогд



сумынхан маань хүүхэд, хөгшидгүй өмнийн говьд сүндэрлэсэн Оюу толгойн уурхайн үйл ажиллагааг зөвөөр ухааран ойлгож талархан дэмжих болсон нь сайшаалтай. Орлого, ашиг, мөнгөний урсгал Оюу толгойг л чиглэж байна шүү дээ. Аливаа бизнес чинь орон нутгийнхантайгаа хэл амаа ололцож, харилцаа холбоогоо бэхжүүлснээр л хөгждөг жамтай хойно. Манай сумын олон иргэн Оюу толгойн уурхайд ажиллаж, ар гэр, амьдрал ахуйгаа авч явна шүү дээ. Манай компанийнхан ч гэсэн “Оюу толгой” гэсэн их айлтай хувь заяагаа холбосон найдвартай түншийн хувьд хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн хөгжүүлэх болно гэдэгтээ итгэлтэй байгаа.

Орон нутгийнхандаа бас тус дэм үзүүлдэг биз дээ?

Одоо чинь компанийн нийгмийн хариуцлага гэж их ярих болж шүү дээ. Орон нутагтаа зүйл

бүрээр тус дэм болохыг хичээдэг юм. Өнгөрсөн жил манай сум 90 жилийн түүхт ойгоо ёслон тэмдэглэсэн, тэр үеэр хандив өргөсөөн. Сум дундын эмнэлэг, ЕБС-ийн анги танхимыг тохижуулах зэрэгт мөн тусалдаг.

Баттулга гэж хүн бизнес эрхлэхийн зэрэгцээ юу сонирхдог бол?

Хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэхийн зэрэгцээ хонь, үхэр, адуу гээд цөөн тооны малтай. Монгол эр хүний ёсоор хурдан морь, бөхийн барилдаанаа шимтэн үзэлгүй яахав. Хээр хөдөөгүүр явахдаа аргаль, янгир, чоно, ирвэс зэрэг ховор ан амьтан үзэж нүд баясгах, зургийг нь авч үлдэх дуртай. Хэдхэн хоногийн өмнө Төв аймгийн Алтанбулаг суманд өвөлжиж байгаа адуугаа эргэсэн чинь тахийн азарга адуутай минь нийлчихээд нэг байдсыг хураасан байна лээ. /Дүрс бичлэгийг нь үзүүлэв. Түүнээс харвал, тахийн азарга монгол азаргатай ноцолдож, ганц нэг байдас, гүүг тасдан хөөхийг оролдож байв/. Тахь нутагшуулж байгаа Хустайн нуруу тэднийхний нутаглаж буй Тариатын амны өвөлжөөнд ойрхон учраас тахийн азарга ийнхүү адуун сүрэгт нийлжээ. Баттулга захирал бас нэг сонин зураг үзүүлэв. Тэр зураг дээр хоёр угалз мөргөлдөж байгаад эврээ орооцолдуулснаас салж чадахгүй байгаа харагдана. Дээрх ховор сонин тохиолдлыг баруун алтайд тодруулбал, Говь-Алтайд аялж явахдаа нүдээр үзэж зурагт буулгасан нь энэ аж.

ХУЛАНГИЙН ХҮЗҮҮВЧ ЦАГ ТУТАМ МЭДЭЭЛЭЛ ӨГНӨ

Хулангийн нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг сансрын хиймэл дагуулын мэдээ дамжуулагч хүзүүвч ашиглан судалж байна

“Оюу толгой” ХХК-ийн Байгаль орчны хэлтэс Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж буй “Өмнөд говийн голлох биологийн олон янз байдлын мониторинг судалгаа” ажлын хүрээнд говь цөлийн ховор тууртан амьтан болох хулангийн нүүдэл, шилжилт хөдөлгөөнд уурхайн дэд бүтцийн үзүүлж буй сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор сансрын хиймэл дагуулын мэдээ дамжуулагч бүхий хүзүүвч ашиглан мэдээлэл цуглуулах ажлыг 2013 оноос гүйцэтгэж байна. Өнгөрсөн 10 дугаар сарын 16-22-нд Байгаль, зэрлэг амьтан хамгаалах



нийгэмлэг, ШУА-ийн Биологийн хүрээлэн, Мал эмнэлгийн төв лаборатори, Австрийн мал эмнэлгийн их сургуулийн Амьтны экологийн судалгааны хүрээлэнгийн эрдэмтэд, Говийн бага

дархан цаазат газрын мэргэжилтнүүд хамтран Ханбогд сумын нутагт Оюу толгойн уурхайн дэд бүтцийн орчим болон Дорноговь аймгийн Хатанбулаг сумын “Эргэлийн зоо” байгалийн нөөц газраас 21 хулан барьж, хүзүүвчлэх ажил хийлээ. Эдгээр хүзүүвч нь хулангийн газарзүйн байршлын мэдээллийг нэг цаг тутамд өгөх бөгөөд хоёр жилийн хугацаатай ажилласны дараа өөрөө салж унах тохируулгатай юм. Судалгааны үр дүнгээр хулангийн улирал, байгаль цаг уурын хүчин зүйлээс хамаарсан нүүдэл, шилжилт хөдөлгөөний хэв маяг, орон зайн байршлыг тогтоохоос гадна дэд бүтэц, ялангуяа Оюу толгойн уурхайгаас Гашуун сухайтын хилийн боомт хүртэлх хатуу хучилттай замын нөлөөллийг тодорхойлж, орон зайн байршилд уул уурхайн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө боловсруулах юм. Өнгөрсөн 2013-2015 онд 20 хуланд ийм сансрын хиймэл мэдээ дамжуулагч зүүж, амжилттай судалгаа хийсэн учраас ажлын үр дүнгээ илүү нарийвчлах зорилгоор үргэлжлүүлж байгаа аж.

*Мэдээлэл бэлдсэн: С. Амарсайхан, Ц. Пүрэвсүрэн
Гэрэл зургийг: Б.Бүүвэйбаатар*

БУРХАН БАГШИЙГ ХОЁР ШАВИЙНХ НЬ ХАМТ ДЭМЧОГИЙН ХИЙДЭД ЗАЛЛАА

Намрын адаг сарын бэлгэт сайн өдөр буюу Бурхан багшийн их дүйчин өдөр Ханбогд сумын нутагт орших дээд амгалант Дэмчогийн хийдэд Бурхан багшийг хоёр шавьтай нь залах их ёслол болов. Бурхан багш гэж бодит хүний хойд дүр нь бурхны оронд үүрд залрах болсон тэр мөчөөс Бурхан багш гэдэг бол ямагт буддын шашины манлайд байх учиртай гэж заасан байдаг байна. Тийм учраас Бурхан багшийн их дүйчин өдрүүдэд олноороо хуран буян үйлдвээс амар амгалан аж төрөх, элбэг хангалуун амьдрах, сэтгэл амгалан болох гээд өчнөөн олон сайн сайхан зүйл хүмүүний амьдралд бий болдог байна.

УИХ-ын гишүүн, Өмнөговь аймгийн нутгийн зөвлөлийн дарга Д.Бат-Эрдэнэ орон нутгийн ард иргэдийн сайн сайхан тусын тулд олон ажлыг хийж гүйцэтгээд байгаа билээ. Түүний захиалгаар Н.Цэдэвсүрэн захиралтай “Зэндмэнэ суварга” ХХК Бурхан багшийг бүтээн Дэмчогийн хийдэд аравнайлан залахад Гандантэгчинлэн хийдийн болон Ханбогд сумын найман лам Дэмчогийн чого номыг хурж, сан тавьж даллага авах шашны их зан үйлийг үйлдлээ. Энэ үеэр гурван насны морь уралдаж, үндэсний 32 бөх





барилдаж, шагайн харвааны тэмцээн болов. Дундговь аймгийн Өндөршил сумын уяач Эрхбаяр азтай одтой сайхан наадаад буцав. Бөхийн барилдаанд аймгийн арслан Ш.Дарханбат түрүүлж үндэсний шагайн харваанд аймгийн заан Батнасан ахлагчтай ахмад харваачдын баг манлайлав. 1000 гаруй сүсэгтэн олон хуран цуглаж хурал номд даган баяссан нь дээдийн буян болохын зэрэгцээ шашин төрөө хүндэтгэж байгаагийн том илрэл боллоо. Дэмчогийн чоно нь эхийн ачийг хариулах дээд амарилангуйн буян оршоох шашны зан үйл юм байна. Эцэг өвгөдөөс уламжилж ирсэн домог түүхт, ариун дагшин Дэмчогийн хийдийг дахин сэргээж Чойнхор чодин буюу Бурхан багшийн их найман үйлд зориулсан цагаан суваргуудыг сүндэрлэн босгосноос хойш УИХ-ын гишүүн Д.Бат-Эрдэнэ энэ хийдэд тасралтгүй 10 жил хөрөнгө оруулалт хийж байгаа нь Монголын нийт сүсэгтэн олонд буян болохын зэрэгцээ түүх соёлын дурсгалт зүйлээ хамгаалах, түүнийг засварлах, сэргээн босгоход чухал дэмжлэг болж байгаа юм. Дэмчогийн шашны ёслолын үеэр ардын жүжигчин, соёлын гавьяат зүтгэлтэн, төрийн хан хуурч Ц.Цэрэндорж, гавьяат жүжигчин С.Вандан, Д.Дуламсүрэн, соёлын тэргүүний ажилтан Э.Төрмандах, Д.Бурмаа нар олны хүртээл болсон олон сайхан дуугаараа ая барьсанд Ханбогдчууд талархалтай байна.

Ханбогд сумын идэвхтэн бичигч Ч.Амгалан

“ОЮУ ТОЛГОЙ”-Н ТОЙМ МЭДЭЭ

“Оюу толгой” компани үйл ажиллагаагаа аюул ослоос ангид тогтвортой явуулж, оролцогч талуудад үр өгөөжөө өгөх үүрэг хүлээсэн билээ. Энэхүү үнэлгээний хуудсаар дамжуулан бид аюулгүй ажиллагаа, байгаль орчин, худалдан авалт, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөрөнгө оруулалт зэрэг үндсэн чиглэлээр олж буй ахиц дэвшлийн талаарх мэдээллийг хүргэх болно.



“ТУСЛАМЖИЙН ГАРАА СУНГАЦГААЯ” САЙН ҮЙЛСИЙН АЯНД ОРОЛЦСОН ТАЙЛАН - “ОЮУ ТОЛГОЙ” ХХК-Д АЖИЛЛАДАГ ӨМНӨГОВЬ АЙМГИЙН УУГУУЛ ИРГЭД

Өмнөговь аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсээс зохион байгуулж байгаа “Тусламжийн гараа сунгацгаая” сайн үйлсийн аянд “Оюу толгой” ХХК-д ажилладаг Өмнөговь аймгийн уугуул иргэд нэгдэж идэвхтэй оролцлоо. Нэн хүнд нөхцөлд амьдарч байгаа иргэдийн амьдрал ахуйг сайжруулах зорилгоор зохион байгуулж байгаа уг аяны уриалгыг хүлээн авч Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 7-р багийн иргэн Сосорын Целкасүрэнд тусламжийн гараа сунгалаа.



Аяны үйл ажиллагаанд бусдыгаа уриалан манлайлан оролцсон Х.Тэгш-Эрдэнэ, Т.Баттулга, П.Нямжав нарт талархал илэрхийлье.

Аяны хүрээнд цугларсан мөнгөөр хоёр тонн нүүрс, хашаа, хаалга барих түүхий эд материалыг худалдан авч “Оюу толгой” ХХК-ийн Өмнөговь аймаг дахь Төлөөлөгчийн газрын хамт олон болон Даланзадгадад хуваарийн амралтаараа ирээд байгаа залуучууд хамтран хашаа хаалгыг хийж Өмнөговь аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн ажилтнуудыг байлцуулан С.Целкасүрэн гуайнд суурилуулж, хүлээлгэн өглөө. Хашаа хийсэн модны тайрдсыг хагалан түлээний модны зориулалтаар мөн хүлээлгэн өглөө.

Эмээ хашаатай болсондоо баярлаж “Хашаатай болчихсон чинь газар маань их том юм шиг болчихлоо. Хавь ойрын хүмүүс мэдээд гайхах байх даа. Эмээ нь “Оюу толгой”-н залуучуудынхаа төлөө цай сүүний дээжээ өргөж, үргэлж залбирч байх болно” гэж ярьж суулаа.

Аяны хүрээнд хийсэн ажлын мөнгөн ба мөнгөн бус ажлын нийт үнэлгээ нь ойролцоогоор 2.5 сая төгрөг боллоо. Энэхүү ажил нь “Олны хүч оломгүй далай” гэгчээр нутгийн залуус сэтгэл нэгдэн хийж бүтээвэл юуг ч хийж бүтээж чадна гэдгийн баталгаа болж, цаашдын хамтын ажиллагааны сайн эхлэл боллоо.

Энэхүү сайн үйлсийн аяныг санаачлан зохион байгуулсан Өмнөговь аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн хамт олон болон аянд нэгдэж гар бие оролцон хамтран ажилласан хүмүүстээ талархал илэрхийлж цаашдын ажилд нь амжилт, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!




“Оюу толгой” ХХК-д ажилладаг Өмнөговь аймгийн уугуул 56 ажилтан мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр уг аяны үйл ажиллагаанд нэгдэж гар бие оролцлоо.

БУУРЫН БОХЬ

Буурын бохь нь буурын орооны үед шилний буюу дагзны арын булчирхайнаас ялгардаг хар бараан өнгөтэй, хурц үнэртэй шингэн шүүрэл юм. Үүнийг малчид гаансны бохьтой төстэй үнэртэй байдгаас “буурын бохь” гэж нэрлэдэг.

Дагзны арын булчирхай нь дагзны болон аман хүзүүний ясны заагийн харалдаа, хоёр чихний хооронд байрлах, доороосоо дээш өргөсч товойсон хүүхдийн бойтгийн тавхай мэт ижил хэлбэр, хэмжээтэй хос булчирхай юм. Уг булчирхай буурын орооны үед идэвхжиж орооны туршид их хэмжээний бохь ялгаруулдаг.



Буурын бохины химийн найрлагыг авч үзэхэд 96 хувийн хуурай бодис агуулж, түүний 2 хувийг тос, 12 хувийг уураг, 9 орчим хувийг нүүрс-ус, 74 хувийг эрдэс бодис эзэлнэ. Эрдсийн бүрэлдэхүүнд кальци (Ca), магни (Mg), натри (Na), кали (K), зэс (Cu), цайр (Zn), манган (Mn), төмөр (Fe) зэрэг олон төрлийн элемент орно. Түүнчлэн ханасан ба ароматик нүүрс устөрөгч, кетон, тосны хүчлийн эфир, амин хүчил, алкалойд болон бусад чухал нэгдлүүдийг агуулж байдаг нь буурын бохийг ардын уламжлалт эмчилгээнд ашиглаж ирсэн үндэслэл юм.

Буурын бохины анагаах чанарын шинжлэх ухааны үндэслэл хараахан эцэслэн тогтоогдоогүй байгаа учир энэхүү зөвлөмжид түүнийг ямар өвчинд хэрхэн хэрэглэх талаар дурдах боломжгүй юм. Гагцхүү бохийг буураас авах, хадгалах явцад гарах нянгийн бохирдлоос сэргийлэх энгийн арга замыг зөвлөж байгаа юм.

Буурын бохийг авах, хадгалахад ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах нь түүнийг эмчилгээний зориулалтаар ашиглах наад захын зайлшгүй шаардлага юм.

Бохь нянгаар бохирдох нь:

Ариун марльд шингээж авсан бохинд нянгийн бохирдол бага, харин үс, ноостой нь хяргаж авсан бохь нянгийн бохирдол ихтэй, хүчтэй эмгэг төрүүлэгч нянгаар бохирдсон байсан нь нян судлалын шинжилгээгээр тогтоогджээ.

Бохины нянгийн бохирдол тухайн буурын маллагааны орчин нөхцөлөөс хамаарч нян үржих нөхцөл бүрддэг байна.

Буурын бохийг ихэнхдээ үстэй нь хяргаж авах, марльд удаан хугацаанд шингээх зэргээр авч, хэзээ, ямар хугацаанд авсан нь тодорхойгүй бохийг эмчилгээнд ууж хэрэглэдэг буруу жишиг тогтсон. Ийм байдлаар бохийг хэрэглэхэд хүний биед нянгийн хордлого үүсгэх эрсдэл учруулж болзошгүй байна.

Тиймээс буурын бохийг авч, хадгалахад ариун цэврийн шаардлага хангасан дараах аргыг хэрэглэхийг зөвлөж байна.

Буураас бохь авах арга:

Буурын орооны хугацаанд бэлчээрт явах үед нь бохийг ариун марльд шингээж өдөр бүр авах аргыг зөвлөж байна. Ингэснээр бохийг бохирдол багатай авах, нэг буураас авах бохины хэмжээг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Бохь авахад шаардагдах материал:

- Ариун марль
- Хайч
- Хүнсний зориулалтын гялгар уут
- Резинэн бээлий
- Урьдчилан бэлтгэсэн хаяг

Аюулгүй ажиллагаа:

- Бохь авахын өмнө буурыг урьдчилан ногтолсон байх
- Бохийг хоёр, түүнээс дээш хүний оролцоотой хамтарч авах
- Бохийг авах үед буурын урд хоёр хөлийг тушиж, толгойг нь доош бөхийлгөн дарж байгаад марлийг тогтоож, бас авч болно.
- Хэрэв буур догшин, зан муутай бол унагаж аюулгүй болгох хэрэгтэй.

Буураас бохь авах ажиллагаа:

- Буур өглөө бэлчээрт гарахаас өмнө марлийг тогтооно.
- Марлийг бохь шингээж авах хэмжээгээрээ хайчлан авч эвхэж бэлтгэнэ. Буурын бохины ялгаралтын хэмжээ тухайн буурын орооны идэвх, зан төлөвтэй холбоотой учир малчид буурынхаа зан байдалд тохируулан нэг удаад 40-80 см орчим марль ашиглаж болно.
- Буурын шилний булчирхай дээрх үсийг хоёр тийш нь ярж байгаад (уг булчирхай дээрх үсийг урьдчилан хяргасан байж болно) бэлтгэсэн марлиа ногтонд хавчуулан тогтоож өөр марлиар гадуур нь ороож бэхлж өгнө. Ингэснээр буур шилээ шөргөөх үед марль унаж гээгдэхээс сэргийлнэ.
- Буурыг бэлчээрт нь явуулаад орой хотондоо ирэхэд нь бохь шингээсэн марлиа авч урьдчилан бэлтгэсэн хүнсний гялгар уутанд хийж хаягжуулж хадгална. Хаягт сум, баг, өрхийн нэр болон буурын нас, зүс, он, сар, өдрийг тодорхой бичсэн байна.

Бохины хадгалалтад анхаарах зүйл:

- Бохь шингээсэн марлийг урьдчилан бэлтгэсэн хаяг бүхий хүнсний зориулалтын гялгар уутанд өдөр өдөрт нь тус тусад нь хийж сэрүүн нөхцөлд хадгалах хэрэгтэй.
- Цуглуулан авсан гялгар ууттай бохио шилэн саванд хийн хөргөгчид хадгалбал илүү зохимжтой. Хэрэв дулаан нөхцөлд удаан хугацаагаар хадгалбал бохь нянгаар бохирдож, химийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох эрсдэлтэй.

ХАНБОГД СУМЫН ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг
Ханбогд сум

Иргэдийн хөгжлийн төв

2015 оны 11-р сарын 09

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ээлжит хурал 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Уулзалтад Ханбогд сумын Захиргааны төлөөлөл, малчдын төлөөлөл, “Оюу толгой” ХХК-ийн төлөөлөл болон Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газрын чиглүүлэгч нар оролцов.

Уулзалтаар хэлэлцсэн гол асуудал нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчин өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны ажлыг хэрэгжүүлэх Олон талт шинжээчдийн багийг сонгон шалгаруулах явдал байлаа. Зөвлөлийн гишүүд энэхүү судалгааг хэрэгжүүлэхээр сонирхлоо ирүүлсэн судалгааны багуудын төслийг хэлэлцсэний эцэст JSL Consulting Ltd, Оксфордын их сургууль болон ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн эрдэмтдийн хамтарсан багаар судалгааг хийлгэхээр санал нэгдлээ.

Мөн уг уулзалтаар 2015 оны 10 дугаар сард хийсэн Ундайн гол дагуу нутагладаг малчин айл өрхүүдийн ажил эрхлэлт, бизнес эрхлэлтийн судалгааны дүнг Зөвлөлийн гишүүдэд танилцуулж, энэ асуудлаар цаашид хийх үйл ажиллагааны талаар хэлэлцэв.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл

Гурван талт зөвлөлийн тухай

Ханбогд сумын сумын удирдлага, малчдын төлөөлөгчид болон “Оюу толгой” компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсны дагуу 2015 оны 6 дугаар сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газраас (ЭНХЗОГ) чиглүүлж байна. ЭНХЗОГ бол Дэлхийн банкны группын Олон улсын санхүүгийн корпорацад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага болно.

Редактор Ч.Батпүрэв

Мэдээллийг бэлтгэсэн: Б.Батбилэг,
Б.Танхилдулам, О.Цогбадрах, Л.Ариунчимэг,
Д.Амарбаясгалан, О.Батзориг, О.Үүрийнтуяа,
Н.Мөнхбаяр, Д.Цэндсүрэн, Ч.Амгалан,
П.Золбуянхишиг

Гэрэл зургийг: Э.Идэрбаатар, А.Хатан-Оол,

Зохион байгуулагч: Н.Сосорбурам

Хэвлэлийн эхийг: Г.Мандах-Оргил

*Та бүхэн “Орон нутгийн сонин”-той
холбоотой санал хүсэлтээ Улаанбаатар
хот болон Ханбогд сум дахь Орон нутгийн
харилцааны ажилтнаар дамжуулан бидэнд
илгээгээрэй.*

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Мөнхис Цамхаг, 1 давхар, Утас: 976-11-331880, Факс: 976-11-331885

Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Цагаан булагийн 8-р баг, “Оюу толгой” ХХК-ийн Өмнөговь дахь Төлөөлөгчийн газар
Утас: 976-7053-3961, 976-7053-3963
Факс: 976-11-331890

Өмнөговь аймаг, Ханбогд сум, Иргэдийн хөгжлийн төв, “Оюу толгой” ХХК-ийн Нийгмийн харилцааны хэлтсийн салбар
Утас: 976-331880 (5316)
976-331880 (7647)

Дэлгэрэнгүй мэдээллийг ot.mn цахим хуудаснаас авна уу.